



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 630.1 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн ТОГТООХ нь:

1. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал С.Бямбаахүүд үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг нэн даруй арилгах арга хэмжээ авах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллах;

2.3. Санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” зарчмыг баримтлан, Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 8 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх;


2.4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг мөрдөж, засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдэл хангасан санхүүгийн баримтаар зарлагын гүйлгээ хийж, санхүүгийн тайланд тусгаж байх;

2.5. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Б.ГАНБАТ

Б.ГАВАА

0000005

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 5 дугаар сарын 28 ний өдрийн
5 дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	"Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хууль зөрчин худалдан авалт хийсэн	Захирал С.Бямбаахүү Ерөнхий ня-бо Б. Даваадулам	402.2	"Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 33.1, 33.2 дахь заалтуудыг мөрдөж ажиллах
2	Гэрээ хэлцэлгүй худалдан авсан ажил үйлчилгээ	Захирал С.Бямбаахүү Ерөнхий ня-бо Б. Даваадулам	120.5	Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах
3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй үргүй зардал	Захирал С.Бямбаахүү Ерөнхий ня-бо Б. Даваадулам	15.4	Монгол Улсын "Төсвийн тухай хууль"-ийг мөрдөж ажиллах
4	Эрх бүхий байгууллагын шийдвэргүй зарцуулсан гадаад арга хэмжээний зардал	Захирал С.Бямбаахүү Ерөнхий ня-бо Б. Даваадулам	92.0	Гадаад албан томилолтын журмыг мөрдөж ажиллах
	Дүн		630.1	